

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

Авлигын эсрэг үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн иргэд,
аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд сурталчлах өдөрлөг
зохион байгуулсан тухай


2024 оны 9 дүгээр сарын 30


Улаанбаатар хот

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон авлигын эсрэг үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд сурталчлах зорилгоор 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 08:00-17:00 цагт Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчилэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон тус дүүргийн 25 хорооны байранд Авлигатай тэмцэх газартай хамтарсан өдөрлөг зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу өдөрлөгийн үеэр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд;

1. Авлигатай тэмцэх газраас хэвлүүлсэн ном, гарын авлагыг хороодод тараах ажлын хүрээнд “Нэгдье” дэвтэр 170 ширхэг, “Авлигатай тэмцэх газар” дэвтэр 99 ширхэг, Бал 260 ширхэг, Брайль үсэгтэй зурагт хуудас 265 ширхэг, “Төрийн бус байгууллага авлигатай тэмцэх нь” ном 30 ширхэг, Шудрага ёс ном 20 ширхэг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 5 ширхэг, “Авлигатай тэмцэхэд хувийн хэвшлийн оролцоо хамтын ажиллагаа” ном 30 ширхэг, “Нэгдье” хөргөгчний наалт 235 ширхэг, Картны кейз /утасны/ 30 ширхэг, “Тат, Түлх” наалт 625 ширхэг, “Нэгдье” дөрвөлжин наалт 150 ширхэг, “Нэгдье” дугуй наалт 450 ширхэг, “Авлигыг мэдээлэх утас 110” дунд хэмжээтэй зурагт хуудас 100 ширхэг, “Нэгдье” зурагт хуудас (Авлига гэдэг нь зөвхөн бэлэн мөнгө солилцох үйлдэл биш, хар өнгөтэй) 60 ширхэг, “Нэгдье” зурагт хуудас (Авлигын эсрэг таны оролцоо юу байх вэ, шар өнгөтэй) 60 ширхэг, “Нэгдье” зурагт хуудас (Авлигын гэмт хэргийн улмаас 2022 онд улсын төсөвт учирсан хохирол, цагаан өнгөтэй) 60 ширхэг, болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хориглолт, хязгаарлалттай холбоотой заалт бүхий 12 төрлийн гарын авлага 1200 ширхэгийг тус тус хүлээн авч 25 хороонд хуваариалан тараасан.







Тараах материал хүлээлцсэн актыг хавсаргав.



2.Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны төрийн албан хаагчдаас төрийн үйлчилгээ авахаар ирсэн Хан-Уул дүүргийн иргэдийн гар утсанд Товш аппликэйшн суулгаж өгсөн.







3. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео шторкийг Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчилэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон 25 хорооны дэлгэцээр явуулж олон нийтэд сурталчлах, иргэдэд “Иргэн та авлигыг эсрэг юу хийж яадах вэ”, “Авлигатай тэмцэх газарт хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах вэ” 2 төрлийн 600 ширхэг гарын авлага тараасан.









ХУД 3-р Хороо СӨХ
Одоо идэвхтэй байна

09:44

Та холбоос дамжууллаа



<https://youtu.be/uuYLfc0pZjs>


Товш


Та холбоос дамжууллаа


<https://youtu.be/zDqNuYnfGHk>

Aa















4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл хийх, гарын авлага тараах.







5.Өдөрлөгийн үеэр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар С.Янжинлхам Иргэдэд үйлчилэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон зарим хорооны өдөрлөгийн үйл ажиллагаатай танилцаж, иргэдийн санал хүсэлтийг сонссон.



Санал;

Хан-Уул дүүргийн иргэдэд үйлчилгээ үзүүлж буй Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Газар зохион байгуулалтын хэлтэс гэх мэт босоо удирдлагатай байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, иргэдэд хүнд сурталгүй түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх талаар холбогдох дээд шатны байгууллагад хандаж үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

Дүгнэлт;

Хан-Уул дүүргийн хэмжээнд төрийн албан хаагчдын оролцоотойгоор Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчилж өдөрлөгт нийт 912 иргэнийг хамруулж мэдээллээр хангасан.

Дүүргийн хэмжээнд төрийн үйлчилгээ авахаар ирсэн 250 орчим иргэний санал, хүсэлтийг сонсоход төрийн үйлчилгээтэй холбоотой хүндрэл бэрхшээл гарах нь харьцангуй багассан боловч Хан-Уул дүүргийн Татварын хэлтэст 1, Газар зохион байгуулалтын албанд 1, Цэцэрлэг, сургуулийн бүртгэлтэй холбоотой 1, нийт 3 иргэнээс төрийн байгууллагын хүнд суртал, иргэдийг мэдээ, мэдээллээр хангахгүй байгаа гомдол гаргасан.

Өдөрлөгийн үеэр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 18 төрлийн 4495 ширхэг ном, гарын авлага, наалтыг хороодоор дамжуулан иргэдэд тараасан бөгөөд Иргэдэд үйлчилэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон 25 хорооны дэлгэцээр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Товш аппликэйшнийг сурталчилах видео шторкийг сурталчлах, мөн төрийн үйлчилгээ авахаар ирсэн 304 иргэний гар утсанд Товш аппликэйшн суулгаж өгсөн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засаг даргын Тамгын газар болон хорооны 180 төрийн албан хаагчид мэдээлэл хийж, хуулиар хориглосон болон хязгаарласан заалт бүхий 12 төрлийн 1200 гарын авлагыг ажлын байран дээр тараасан.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.МӨНХГЭРЭЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.САРАНЦАЦРАЛ